



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Уланбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 28-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategnaabuirii@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024. 09. 03 № 14

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД ЛУВСАННАМСРАЙН
ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Г Боловсролын салбарын хамтын
хэлэлцээрийн талаар

Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооноос 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн 2024/18 тоот албан бичгээр миний нэр дээр боловсролын салбарын хамтын хэлэлцээрт оролцож чадахгүй, гишүүдийн эрх ашиг зөрчигдэж байгаа талаар дурдан хүсэлт ирүүлжээ.

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Тухайн байгууллагад хоёр, түүнээс дээш үйлдвэрчний эвлэл байвал тэдгээр нь тохиролцож, хамтарсан төлөөлөгчид томилон захиргаа, эзэдтэй хамтын нэг гэрээ байгуулна.", 3 дахь хэсэгт "Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсгийн заалтууд үйлдвэрчний эвлэлийн орон нутгийн болон улсын хэмжээний холбоодод нэг адил хамаарна. /Энэ тохиолдолд "захиргаа" гэдэгт БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захиралмжах дээд, төв болон орон нутгийн байгууллагыг хамааруулан ойлгоно/", Хөдөлмөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт "Улс, аймаг, сум, нийслэл, дүүрэг, салбарын хэмжээнд хэд хэдэн үйлдвэрчний эвлэл, ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага байвал хамтын хэлэлцээнд оролцох төлөөлөгчдийн тоог гишүүдийнхээ тооны харьцааг үндэслэн тогтооно." гэж тус тус заасан байна.

Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй.", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашигийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй.", Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлийн 1-ийн (а) хэсэгт "хүн бүр эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлоо хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрчний эвлэл байгуулах, журмыг нь сахих үндсэн дээр сонгосон байгууллагадаа элсэн орох эрхтэй. Дээр дурдсан эрхийг эдлэхэд хуульд заасан буюу ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалт тогтоохыг хориглоно", 1-ийн (б) хэсэгт "үйлдвэрчний эвлэлээс үндэсний холбоо, нэгдэл байгуулах эрх, түүнчлэн үндэсний холбоо, нэгдлээс олон улсын үйлдвэрчний байгууллагыг үүсгэх буюу түүнд нэгдэн орох эрх", 1-ийн (с) хэсэгт "үйлдвэрчний эвлэл хуулиар тогтоосон бөгөөд ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй

20240020

байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаагаа саадгүй явуулах эрх” –ийг тус тус хангах үүрэгтэй гэж заасан байдаг.

Гэтэл эдгээр хууль тогтоомж болон олон улсын нийтээр хулээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ хэрэгжихгүй, Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооны олон мянган гишүүд төлөөллөө салбарын хэлэлцээрт оруулж чадахгүй хохирсоор байгааг мөн дурджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 2.1/ “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;”, 2.5/ дахь хэсэгт “терийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;”, 2.7/ “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэж тус тус заасан байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дахь хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоог Боловсролын салбарын хамтын хэлэлцээрт оролцуулахгүй байх ямар шалтгаан байгаа, хэлэлцээрт оролцох эрхтэй эсэх талаарх Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн тус бүрийн албан ёсны тайлбарыг бичгээр авч ирүүлэх;
2. Монгол Улсын Засгийн газрын зүгээс цаашдаа Хөдөлмөр нийгмийн зөвшлийн үндэсний гурван талт хэлэлцээр, салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрүүдийг үр дүнтэй, боловсронгуй болгох, тэдгээрт үйлдвэрчний эвлэлүүдийн оролцоог хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг ирүүлэх;

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

Жич: Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооноос 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн 2024/18 тоот Хүсэлт гаргах тухай албан бичгийн хуулбарыг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

В.

Ц.МОНХТУЯА

20240070